



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/56

Мандалговь

Мэргэжлийн баг томилох тухай


Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2012 оны “Дархлаажуулалтын тухай” 217, Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” А/278, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Дархлаажуулалтын хороо байгуулах тухай” А/315, А/316 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн үед ажиллах мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл гарсан үед багийн гишүүдийг удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган, авах арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг багийн ахлагч Хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн (П.Оюунчимэг)-д даалгасугай.

ДАРГА  Б.АЛТАНТӨГС



Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн
А/56 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ УРВАЛ, ХҮНДРЭЛИЙН ҮЕД
АЖИЛЛАХ МЭРГЭЖЛИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Багийн ахлагч: Эрүүл мэндийн газрын дархлаажуулалт хариуцсан
мэргэжилтэн
- Гишүүд: Эрүүл мэндийн газрын хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн
Нэгдсэн эмнэлгийн чанарын менежер
Нэгдсэн эмнэлгийн мэдрэлийн эмч
Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эмч
Нэгдсэн эмнэлгийн мэс заслын эмч
Нэгдсэн эмнэлгийн клиник лабораторийн эмч

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн
А/56 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН БАГИЙН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн шалтгаан хамаарлыг тогтоох мэргэжлийн баг нь сэргийлэх тарилга буюу дархлаажуулалтын улмаас хүний эрүүл мэндэд учирсан тогтвортой эсхүл ноцтой хямралд хийсэн шалтгаан хамаарлыг үнэлэн, санал, дүгнэлт зөвлөмж гаргах үндсэн үүрэг бүхий орон тооны бус баг юм.

Хоёр. Мэргэжлийн багийн үйл ажиллагааны чиглэл

- 2.1. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл (ДДУХ)-ийн тохиолдолын мэдээ авмагц мэргэжлийн баг ажиллана.
- 2.2. ДДУХ-ийн багц болон ноцтой тохиолдлуудад судалгаа хийж, шалтгаан хамаарлыг тогтоон санал, дүгнэлт, зөвлөмж гаргах
- 2.3. Мэргэжлийн баг нь ДДУХ-ийн тохиолдлын шалтгааныг тогтоох зорилгоор дархлаажуулалттай холбоотой бүх үйл ажиллагааг хянан нарийвчилсан судалгааг ажлын 3 хоногт багтаан хийж, эхний дүгнэлтийг гарган, Эрүүл мэндийн газрын эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагчид хүргүүлж, ДДУХ-ийн сэжигтэй тохиолдлыг магадлан тогтооно.
- 2.4. ДДУХ-ийн сэжигтэй тохиолдолд үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээг хянаж, шаардлагатай тохиолдолд дараагийн шатны эмнэлэгт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.5. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн багийн гишүүдийг оролцуулан шалтгаан хамаарлыг үнэлэх багийн дахин томилж, үнэлгээнд мэргэжил арга зүйн дэмлэг туслалцаа үзүүлэх.
- 2.6. ДДУХ-ийн тандалтын явцтай танилцан мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх.